



## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 8192

Чойр

### Хүнд даацын автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны өрөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн  
**ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Дулааны улирал эхлэн хөрсөнд гэсэлт явагдаж, авто замын далан суурьт хэв гажилт үүсч, замын хучилтын эвдрэл нэмэгдэх, хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдал үүсч байгаа тул Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэр дэх улсын чанартай авто зам, замын байгууламжаар “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих шаардлага MNS:4598:2020” стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн ачаа тээвэрлэсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн хориглосугай.

2. Хөдөлгөөн хязгаарласан хугацаанд замын хөдөлгөөнд оролцож байгаа том оврын болон хүнд даацын авто тээврийн хэрэгсэлд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулан замын хөдөлгөөнд оролцуулах, холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх, хүнд даацын авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөн хязгаарласан тухай мэдээг ачаа үүсгэгч, тээвэрлэгч болон олон нийтэд хүргэх, зам тээврийн хяналтыг эрчимжүүлэн, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга (хурандаа Ц.Баярхүү), Авто тээврийн үндэсний төвийн Говьсүмбэр салбарын дарга (Н.Мөнхнаран), А33А-ын “Саруул харгуй” ХХК-ийн захирал (Б.Содмөнх) нарт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханган, үр дүнг 7 хоног бүр танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Нэргүйцэцэг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ

